

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД, БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН
ХӨГЖЛИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2014 оны 03 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 11.1А-84

Улаанбаатар
хот

Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.1, 24 дүгээр зүйлийн 24.2, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4, Ойн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ой, хээрийг түймрээс хамгаалах үйл ажиллагааг зохицуулах үндэсний зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Зөвлөлийн дарга	Байгаль орчин, ногоон хөгжлийн дэд сайд;
Зөвлөлийн орлогч дарга	Засгийн газрын тохируулагч агентлаг Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга;
Нарийн бичгийн дарга	Дэлхийн түймрийн мониторингийн төвийн Монгол дахь суурин төлөөлөгч
Гишүүд:	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга; Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга; Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газрын дарга; Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Ой хамгаалал, ойжуулалтыг зохицуулах хэлтсийн дарга; Цагдаагийн ерөнхий газрын Хэрэг бүртгэх хэлтсийн дарга /тохиролцсоноор/; Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын газрын дарга /тохиролцсоноор/;

Батлан хамгаалах яамны Зэвсэгт хүчний жанжин штабын Цэргийн хангалт, үйлчилгээний газрын Экологи, уул уурхайн албаны дарга /тохиролцсоноор/;

Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын дарга /тохиролцсоноор/;

Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх газар, Мөрдөн байцаах газрын Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг мөрдөх хэлтсийн дарга /тохиролцсоноор/;

Хил хамгаалах ерөнхий газрын Хилийн хэлтсийн дарга /тохиролцсоноор/

2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн "Үндэсний зөвлөл байгуулах тухай" 69/289 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Д.ТЭРБИШДАГВА



С.ОЮУН